



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нарэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16

E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2018. 01. 04 № 01

Асуулга тавих тухай

Сүүлийн үед техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн боловсруулсан, холбогдох судалгаанууд нь хийгдсэн, хөрөнгө оруулалт хийхэд бэлэн болсон төсөл маш цөөн байгаа тухай шүүмжлэл тогтмол яригдаж байна.

Гэтэл нөгөө талд нь, Төслийн нэгж, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Ашиглалтын өмнөх захиргаа гэх мэт нэртэй зорилго, чиг үүрэг нь ойлгомжгүй, олон ажилтны орон тоотой ч үр дүн гардаггүй, төсвийн мөнгийг олон жилээр үр ашиггүй үрсэн, тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан зорилгоо биелүүлж амжилгүй татан буугдсан зэрэг төслийн нэгжүүд яам, орон нутагт цөөнгүй байх боллоо.

Үүнийг төрөөс төслийн нэгжүүдийн үйл ажиллагаа, үр дунд тавих хяналт, хариуцлага суларсантай холбоотой гэж үзэж байгаа тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын хэмжээнд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа хэдэн төслийн нэгж байгаа, түүнд нийт хичнээн хүн ажиллаж байгаа, тэдгээрийг төсвөөс болон гадаад зээл тусlamжийн шугамаар хичнээн төгрөгөөр санхүүжүүлж байгаа, төслүүдийн үр дүн, зардлаа нөхөх хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?
2. Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх төслүүдийг ямар шалгуур, үндэслэл, үзүүлэлтээр сонгож Төслийн нэгж байгуулдаг, одоогоор урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд бэлэн болсон ямар ямар төсөл, төслийн нэгжүүд байгааг салбар, яамдаар гаргаж мэдээлнэ үү?
3. Төслийн нэгжүүдийг ямар нөхцөлд, ямар хугацаагаар, ямар зорилгыг хэрэгжүүлэх үүрэгтэйгээр, ямар дүрэм журмын дагуу байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж хариуцлага тооцож байна вэ?
4. Өнгөрсөн хугацаанд ямар ямар төслийн нэгж хичнээн төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж үр дүнтэй хэрэгжсэн ба ямар нэгжүүд үр дүнгүй ажиллаж татан буулгасан бэ. Мөн зорилго, үр дүндээ хүрсэн эсвэл хэрэгжих боломжгүй нь тодорхой болсон төслийн нэгжүүдийг татан буулгах эсэх.

5. Төслийн нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэр ямар бүтэцтэй байна вэ, удирдлага, зөвлөх үйлчилгээний зардал нийт зардлын хэдэн хувийг эзэлж байгаа, тухайн төслүүд нь зээлээр хэрэгждэг бол зээлийн хугацаа, хүүний талаарх мэдээллийг өгнө үү?
6. Үйл ажиллагаа нь түр болон бүр зогссон, нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай ямар төслийн нэгжүүд байна вэ?
7. Цаашид төслийн нэгжүүдийн үйл ажиллагааг үр дүнтэй, ил тод, хуулийн дагуу явуулах талаар ямар арга хэмжээ авч ажиллах вэ?

Эдгээр асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

С.БЯМБАЦОГТ

